ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:САГ-2026/233/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор**
**Ц.Наранчимэг**
Утас:51-261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: В.Эрдэнэцогт**
Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
**Ахлах аудитор: М.Пагамдулам**
Утас: 261628 Цахим хаяг:pagamdulamm@audit.gov.mn
**Аудитор Б.Отгонцэцэг**
Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn

Улаанбаатар хот
2026 он

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3**
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 6**
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 13**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 15
**4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 18**
4.1 Ерөнхий зүйл ..... 18
4.2 Материаллаг байдал ..... 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 20
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 21**
5.1 Төлбөрийн акт ..... 21
5.2 Албан шаардлага ..... 22
5.3 Зөвлөмж ..... 26
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 27**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/307

танай _____-ны № _____-т

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.АНХТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 129,897.7 мянган төгрөгийн гэрээг дүгнээгүй, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- Хамаарал бүхий этгээдээс 283,588.8 мянган төгрөгийн хандив авсан;
- Түрээслэгч байгууллагуудаас гэрээний дагуу 45,041.5 мянган төгрөгийн барьцаа төлбөрийг аваагүй;
- Эмнэлгийн 2 дугаар давхарт байрлах 288 мкв талбайг Үлэмж эс жи жи ХХК-д үнэ төлбөргүй ашиглуулж 51,840.0 мянган төгрөгийн түрээсийн орлого бүрдүүлээгүй;
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 224,696.4 мянган төгрөгийг зарцуулсан;
- Төлбөртэй өрөөний 241,439.0 мянган төгрөгийн орлогын тооцоо бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 25 дугаар зүйлийн 25.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-21.Docx

1526140614

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайланд онд 1,000,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй эмийн автомат савлалтын машин болон агуулахын нэгдсэн системийг бэлтгэн нийлүүлж, Монгол Улсад анх удаа орчин үеийн стандартад нийцсэн эмийн чанар, хадгалалт, хяналт, нөөцийн удирдлагын ухаалаг цогц системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/190 дүгээр тушаалаар "Эмнэлгийн тусламж үйлчилгээ, хэрэглэгчийн сэтгэл ханамж, санхүү нөөц бүртгэлийн системийг оновчтой, үр ашигтайгаар зохион байгуулах" зорилгоор Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг автомажуулах IOT технологийг нэвтрүүлж 100,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчний жагсаалтад орсон нүүрний мэдрэлийн хавдар авах мэс заслыг анх удаа чихний гадна сувгаар дамжуулан хийх аргыг шинээр нэвтрүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлэзд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yewsan_Bichig\2026\0225 SAG-21.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **50,742,055,958.13** | **30,694,410,861.39** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **3,659,411,363.68** | **832,621,792.43** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 3,659,411,363.68 | 832,621,792.43 |
| 31210 | Төгрөг | 3,659,411,363.68 | 832,621,792.43 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 3,659,411,363.68 | 832,621,792.43 |
| **33** | **АВЛАГА** | **16,861,754,873.90** | **3,055,661,069.22** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 90,964.30 | 130,072.88 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 16,609,727,830.72 | 2,765,726,258.95 |
| 33500 | Бусад авлага | 251,936,078.88 | 289,804,737.39 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 227,641,878.88 | 279,468,737.39 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 24,294,200.00 | 10,336,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **68,041,288.60** | **4,483,959,986.91** |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 68,041,288.60 | 4,483,959,986.91 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 68,041,288.60 | 4,483,959,986.91 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **30,152,848,431.95** | **22,322,168,012.83** |
| 35100 | Түүхий эд материал | 24,400,159,619.51 | 16,053,132,390.55 |
| 35130 | Эм боох материал | 24,400,159,619.51 | 16,053,132,390.55 |
| 35400 | Хангамжийн материал | 5,752,688,812.44 | 6,269,035,622.28 |
| 35420 | Аж ахуйн материал | 69,470,874.22 | 100,419,217.03 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 312,622,385.12 | 308,518,747.96 |
| 35450 | Барилгын засварын материал | 42,387,163.55 | 33,554,883.57 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,328,208,389.55 | 5,826,542,773.72 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,271,546,541.02** | **65,134,390,376.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **52,271,546,541.02** | **65,134,390,376.86** |
| 39200 | Биет хөрөнгө | 51,430,600,106.33 | 64,148,061,129.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 28,960,517,430.49 | 30,343,630,217.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (2,617,690,216.54) | (3,112,102,467.34) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,011,392,007.80 | 840,773,632.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (242,872,970.15) | (216,580,547.01) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 72,827,234,015.88 | 57,777,264,988.11 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (50,289,577,854.81) | (23,260,597,327.92) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,122,555,049.02 | 930,671,961.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (819,396,786.57) | (535,769,860.16) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,979,871,366.71 | 1,799,419,559.16 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (501,431,935.50) | (418,649,027.11) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 840,946,434.69 | 986,329,247.84 |
| 39301 | Програм хангамж | 122,891,903.00 | 212,200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (112,330,568.31) | (56,255,852.16) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 830,385,100.00 | 830,385,100.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **103,013,602,499.15** | **95,828,801,238.25** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **25,793,148,849.13** | **13,152,634,348.73** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **25,793,148,849.13** | **13,152,634,348.73** |
| 41300 | Өглөг | 25,793,148,849.13 | 13,152,634,348.73 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 23,053,381.15 | 19,979,342.25 |
| 41360 | Бусад өглөг | 25,770,095,467.98 | 13,132,655,006.48 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 25,770,095,467.98 | 13,132,655,006.48 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **77,220,453,650.02** | **82,676,166,889.52** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 77,220,453,650.02 | 82,676,166,889.52 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 21,376,629,291.33 | 21,376,629,291.33 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 21,376,629,291.33 | 21,376,629,291.33 |

| | | | |
|---|---|---|---|
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 46,429,230,425.55 | 51,884,943,665.05 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 46,414,905,153.02 | 46,429,230,425.55 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 14,325,272.53 | 5,455,713,239.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 9,414,593,933.14 | 9,414,593,933.14 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **103,013,602,499.15** | **95,828,801,238.25** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **92,480,759,182.86** | **110,443,465,083.23** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,480,788,422.24** | **110,443,465,083.23** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 12,480,788,422.24 | 33,477,375,691.23 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,393,225,027.64 | 13,223,191,520.28 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,408,718,665.66 | 7,476,833,506.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,984,506,361.98 | 5,746,358,014.28 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,368,078,368.46 | 18,860,724,622.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 719,485,026.14 | 1,393,459,548.35 |
| 122 | Тусламжийн орлого | - | 76,966,089,392.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 76,966,089,392.00 |
| 12215 | Төсөв хоорондын хандив,тусламж | - | 76,966,089,392.00 |
| 122151 | Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\ | - | 76,966,089,392.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **79,999,970,760.62** | **-** |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 79,999,970,760.62 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 79,999,970,760.62 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **92,466,433,910.33** | **104,968,712,300.34** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 92,466,433,910.33 | 104,968,712,300.34 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 91,918,365,792.33 | 104,268,007,628.34 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 30,035,995,269.07 | 31,651,675,698.44 |
| 210101 | Үндсэн цалин | 17,371,211,742.12 | 18,986,568,948.65 |
| 210102 | Нэмэгдэл | 9,430,585,911.02 | 9,192,570,035.93 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,745,607,590.00 | 1,785,390,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,488,590,025.93 | 1,687,146,713.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,866,564,489.14 | 4,034,091,568.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 2,597,779,644.11 | 2,697,102,928.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 305,274,439.02 | 322,664,848.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 249,454,466.66 | 268,369,910.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 139,858,979.74 | 148,041,180.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 574,196,959.61 | 597,912,700.74 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,498,198,437.16 | 1,702,583,371.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 704,988,354.68 | 1,006,724,863.52 |
| 210302 | Түлш, халаалт | 270,688,974.07 | 227,405,385.06 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 522,521,108.41 | 468,453,123.24 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 841,995,988.74 | 1,793,653,568.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 244,218,613.33 | 467,386,150.14 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 54,547,817.02 | 59,171,170.46 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 30,307,910.62 | 31,606,457.58 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 511,109,189.12 | 1,193,971,888.32 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,812,458.65 | 41,517,902.00 |
| 2105 | Норматив зардал | 47,254,894,648.40 | 55,688,899,271.65 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 45,554,848,348.40 | 53,790,882,021.65 |
| 210502 | Хоол, хүнс | 1,700,046,300.00 | 1,898,017,250.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,016,995,596.65 | 1,284,188,453.39 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,170,353.65 | 36,301,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,004,825,243.00 | 1,247,887,253.39 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 161,801,089.40 | 44,766,400.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 13,592,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 148,209,089.40 | 44,766,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,336,198,275.52 | 816,613,248.69 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,274,372,327.52 | 770,420,608.69 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16,500,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,426,308.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 678,600.00 | 678,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 143,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 36,840,000.00 | 39,990,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,381,040.00 | 5,381,040.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,905,721,998.25 | 7,251,536,047.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 513,128,120.63 | 618,571,042.21 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 5,392,593,877.62 | 6,632,965,005.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 548,068,118.00 | 700,704,672.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 548,068,118.00 | 700,704,672.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 421,120,900.00 | 686,468,672.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 126,947,218.00 | 14,236,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **14,325,272.53** | **5,474,752,782.89** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **19,039,543.39** |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | - | 19,039,543.39 |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **-** | **(19,039,543.39)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **14,325,272.53** | **5,455,713,239.50** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **90,404,802,117.70** | **103,252,548,993.56** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,215,107,337.73 | 103,252,548,993.56 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,215,107,337.73 | 12,442,458,029.79 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,215,107,337.73 | 12,442,458,029.79 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,379,875,844.37 | 7,389,734,283.79 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,835,231,493.36 | 5,052,723,746.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 90,810,090,963.77 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 90,810,090,963.77 |
| 12215 | Төсөв хоорондын хандив,тусламж | - | 90,810,090,963.77 |
| 122151 | Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\ | - | 90,810,090,963.77 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **80,189,694,779.97** | **-** |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 80,189,694,779.97 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 80,189,694,779.97 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗӨЭЛИЙН ДҮН** | **86,533,953,757.92** | **105,711,807,884.81** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **86,533,953,757.92** | **105,711,807,884.81** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 85,985,885,639.92 | 105,011,103,212.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 30,036,145,264.08 | 32,670,175,112.34 |
| 210101 | Үндсэн цалин | 16,049,495,489.86 | 20,044,370,147.81 |
| 210102 | Нэмэгдэл | 10,759,932,461.39 | 9,158,406,069.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,741,859,192.92 | 1,785,947,603.15 |
| 210104 | Урамшуулал | 1,484,858,119.91 | 1,681,451,291.57 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,938,015,579.43 | 2,907,778,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 2,978,521,079.43 | 1,963,379,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 239,873,600.00 | 236,100,000.00 |



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 119,936,800.00 | 118,050,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 119,936,800.00 | 118,050,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 479,747,300.00 | 472,199,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,503,618,271.51 | 1,704,341,114.12 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 704,988,354.68 | 946,605,802.91 |
| 210302 | Түлш, халаалт | 276,108,808.42 | 289,282,187.97 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 522,521,108.41 | 468,453,123.24 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 594,483,432.62 | 594,292,227.58 |
| 210401 | Бичиг хэрэг | 103,781,700.00 | 103,837,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 68,966,600.00 | 50,545,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 30,188,310.62 | 31,606,457.58 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 325,897,948.00 | 359,899,370.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 65,648,874.00 | 48,403,800.00 |
| 2105 | Норматив зардал | 45,507,239,416.90 | 63,849,487,305.46 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 43,683,341,748.90 | 61,463,533,705.46 |
| 210502 | Хоол, хүнс | 1,742,053,223.00 | 2,114,537,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 81,844,445.00 | 271,416,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,103,224,851.03 | 2,036,587,485.02 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 943,421,640.03 | 1,228,126,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,159,803,211.00 | 808,460,685.02 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 122,611,312.00 | 19,132,100.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 19,572,276.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 103,039,036.00 | 19,132,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,873,127,148.02 | 910,028,448.69 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,719,241,138.02 | 827,110,108.69 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16,500,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,123,500.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 678,600.00 | 678,600.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 143,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 114,625,000.00 | 54,840,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,381,040.00 | 5,381,040.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 14,577,870.00 | 21,875,700.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 307,420,364.33 | 319,280,519.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 307,420,364.33 | 319,280,519.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 548,068,118.00 | 700,704,672.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 548,068,118.00 | 700,704,672.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 527,728,118.00 | 686,468,672.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 20,340,000.00 | 14,236,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **3,870,848,359.78** | **(2,459,258,891.25)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **562,320,214.26** | **367,530,680.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **562,320,214.26** | **367,530,680.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 562,320,214.26 | 367,530,680.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 562,320,214.26 | 367,530,680.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(562,320,214.26)** | **(367,530,680.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **3,308,528,145.52** | **(2,826,789,571.25)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 350,883,218.16 | 3,659,411,363.68 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,659,411,363.68 | 832,621,792.43 |
| 99 | Хамаарахгүй | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **21,376,629,291.33** | **9,414,593,933.14** | **46,414,905,153.02** | **77,206,128,377.49** |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,376,629,291.33 | 9,414,593,933.14 | 46,414,905,153.02 | 77,206,128,377.49 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 14,325,272.53 | 14,325,272.53 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **21,376,629,291.33** | **9,414,593,933.14** | **46,429,230,425.55** | **77,220,453,650.02** |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,376,629,291.33 | 9,414,593,933.14 | 46,429,230,425.55 | 77,220,453,650.02 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 5,455,713,239.50 | 5,455,713,239.50 |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **21,376,629,291.33** | **9,414,593,933.14** | **51,884,943,665.05** | **82,676,166,889.52** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **105,069,863,500.00** | **103,252,548,993.56** | **1,817,314,506.44** | **98.3** |
| **12** | **Татварын бус орлого** | **105,069,863,500.00** | **103,252,548,993.56** | **1,817,314,506.44** | **98.3** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 13,809,047,600.00 | 12,442,458,029.79 | 1,366,589,570.21 | 90.1 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 8,233,510,000.00 | 7,389,734,283.79 | 843,775,716.21 | 89.8 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 5,575,537,600.00 | 5,052,723,746.00 | 522,813,854.00 | 90.6 |
| 122 | Тусламжийн орлого | 91,260,815,900.00 | 90,810,090,963.77 | 450,724,936.23 | 99.5 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 91,260,815,900.00 | 90,810,090,963.77 | 450,724,936.23 | 99.5 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 108,729,275,000.00 | 106,079,338,564.81 | 2,649,936,435.19 | 97.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **108,729,275,000.00** | **106,079,338,564.81** | **2,649,936,435.19** | **97.6** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 107,618,276,600.00 | 105,378,633,892.81 | 2,239,642,707.19 | 97.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 33,954,688,200.00 | 32,670,175,112.34 | 1,284,513,087.66 | 96.2 |
| 210101 | Үндсэн цалин | 21,004,467,200.00 | 20,044,370,147.81 | 960,097,052.19 | 95.4 |
| 210102 | Нэмэгдэл | 7,271,730,100.00 | 9,158,406,069.81 | (1,886,675,969.81) | 125.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,703,363,300.00 | 1,785,947,603.15 | 1,917,415,696.85 | 48.2 |
| 210104 | Урамшуулал | 1,975,127,600.00 | 1,681,451,291.57 | 293,676,308.43 | 85.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,907,778,900.00 | 2,907,778,900.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,963,379,000.00 | 1,963,379,000.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 236,100,000.00 | 236,100,000.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 118,050,000.00 | 118,050,000.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 118,050,000.00 | 118,050,000.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 472,199,900.00 | 472,199,900.00 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,704,348,800.00 | 1,704,341,114.12 | 7,685.88 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 918,706,300.00 | 946,605,802.91 | (27,899,502.91) | 103.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 317,184,200.00 | 289,282,187.97 | 27,902,012.03 | 91.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 468,458,300.00 | 468,453,123.24 | 5,176.76 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 641,103,700.00 | 608,592,227.58 | 32,511,472.42 | 94.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 103,837,600.00 | 103,837,600.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 50,550,000.00 | 50,545,000.00 | 5,000.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 33,333,000.00 | 31,606,457.58 | 1,726,542.42 | 94.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 389,492,000.00 | 359,899,370.00 | 29,592,630.00 | 92.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 63,891,100.00 | 62,703,800.00 | 1,187,300.00 | 98.1 |
| 2105 | Норматив зардал | 64,204,456,700.00 | 63,849,487,305.46 | 354,969,394.54 | 99.4 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 61,811,528,300.00 | 61,463,533,705.46 | 347,994,594.54 | 99.4 |
| 210502 | Хоол, хүнс | 2,114,537,100.00 | 2,114,537,100.00 | - | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 278,391,300.00 | 271,416,500.00 | 6,974,800.00 | 97.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,264,981,500.00 | 2,264,938,165.02 | 43,334.98 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,308,798,100.00 | 1,308,765,580.00 | 32,520.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 956,183,400.00 | 956,172,585.02 | 10,814.98 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 22,879,600.00 | 19,132,100.00 | 3,747,500.00 | 83.6 |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,879,600.00 | 19,132,100.00 | 3,747,500.00 | 83.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,235,630,200.00** | **1,034,908,448.69** | **200,721,751.31** | **83.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,076,504,000.00 | 886,910,108.69 | 189,593,891.31 | 82.4 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,000,000.00 | - | 9,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,123,500.00 | - | 2,123,500.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 678,600.00 | 678,600.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 143,000.00 | 143,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 119,920,000.00 | 119,920,000.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 5,385,400.00 | 5,381,040.00 | 4,360.00 | 99.9 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 21,875,700.00 | 21,875,700.00 | - | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 682,409,000.00 | 319,280,519.60 | 363,128,480.40 | 46.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 682,409,000.00 | 319,280,519.60 | 363,128,480.40 | 46.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,110,998,400.00** | **700,704,672.00** | **410,293,728.00** | **63.1** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,110,998,400.00 | 700,704,672.00 | 410,293,728.00 | 63.1 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,052,062,500.00 | 686,468,672.00 | 365,593,828.00 | 65.2 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 58,935,900.00 | 14,236,000.00 | 44,699,900.00 | 24.2 |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **(3,659,411,500.00)** | **(2,826,789,571.25)** | **(832,621,928.75)** | **77.2** |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,659,411,500.00** | **2,826,789,571.25** | **832,621,928.75** | **77.2** |
| **7** | **Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт** | **3,659,411,500.00** | **2,826,789,571.25** | **832,621,928.75** | **77.2** |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **3,659,411,363.68** | **(3,659,411,363.68)** | **-** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **832,621,792.43** | **(832,621,792.43)** | **-** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1,595.00** | **339,259.00** | **(337,664)** | **-** |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 797.00 | 803.00 | (6) | 100.8 |
| 620001 | Удирдах ажилтан | 2.00 | 13.00 | (11) | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 620.00 | 752.00 | (132) | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 175.00 | 29.00 | 146 | - |
| 620004 | Гэрээт ажилтан | 0.00 | 9.00 | (9) | - |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | 337,652.00 | (337,652) | - |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | - | 21,022.00 | (21,022) | - |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо | - | 316,630.00 | (316,630) | - |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 797.00 | 803.00 | (6) | 100.8 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 622.00 | 659.00 | (37) | 105.9 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 175.00 | 144.00 | 31 | 82.3 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын нэгдүгээр төв эмнэлэг стратеги зорилгоо "эмчилгээ, сувилгаа, үйлчилгээ, орчны шинэчлэлийг олон улсын түвшинд нийцүүлэн сайжруулж, инновац, эрдэм шинжилгээ судалгааны хамрах хүрээг өргөжүүлэн эмнэлгийн мэргэшсэн, нэгдмэл цогц, тусламж үйлчилгээг салбарын анхдагч, үндэсний манлайлагчаас дэлхийн жишигт хүргэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэлхийн жишигт хүргэх чадварлаг хүний нөөцийг гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоог бий болгох замаар хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж залгамж халааг тасралтгүй бэлтгэх;
- ОУ-ын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар оношилгоо, эмчилгээний шинэ технологи, инновац, сайн туршлага, менежментийг нэвтрүүлэн нутагшуулж, Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчний тоог бууруулах;
- Байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн менежмент, гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулах замаар санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг дэмжсэн уян хатан тогтолцоог хөгжүүлэхийг эрмэлзэж ажиллах;
- Олон улсын магадлан итгэмжлэлийн стандартуудыг хангасан эрсдэлгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орчинг бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцооны хамрах хүрээг өргөжүүлэн, өрсөлдөх чадвараа бэхжүүлэх;

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус эмнэлэг нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд эмнэлгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал дараах хууль, журамд нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хуульд;
- Төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын А/3 дугаар тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг шинэчлэн батлсан;
- ЭМДҮЗ-ийн 3 дугаар тогтоолоор "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам", 4 дүгээр тогтоолоор "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам"-ыг шинэчлэн батлсан байна.

Эмнэлгийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод бараа материалын эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар бүртгэдэг байсныг дундаж өртгийн аргаар бүртгэдэг болгож өөрчилсөн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,184,801.3 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 3,659,411.4 | 832,621.8 | (2,826,589.6) |
| Авлага | 16,861,754.9 | 3,055,661.1 | (13,806,093.8) |
| Урьдчилгаа | 68,041.3 | 4,483,960.0 | 4,415,918.7 |
| Бараа материал | 30,152,848.4 | 22,322,168.0 | (7,830,680.4) |
| Үндсэн хөрөнгө | 52,271,546.5 | 65,134,390.4 | 12,862,843.8 |
| **Нийт хөрөнгө** | **103,013,602.5** | **95,828,801.2** | **(7,184,801.3)** |
| Өр төлбөр | 25,793,148.8 | 13,152,634.3 | (12,640,514.5) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 77,220,453.7 | 82,676,166.9 | 5,455,713.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **103,013,602.5** | **95,828,801.2** | **(7,184,801.3)** |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 832,621.8 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 2,826,789.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Авлагын дансны үлдэгдэл 3,055,661.1 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 13,806,093.8 мянган төгрөгөөр буурахад ЭМДС-аас авах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлага 13,844,001.6 мянган төгрөг, нийгмийн даатгалаас авах авлагыг 113,818.2 мянган төгрөгөөр тус тус барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 4,483,960.0 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 4,415,918.7 мянган төгрөгөөр нэмэгдэхэд Недерланд улсын "Астеллас Фарма" компанид дархлаа дарангуйлах /Такролимус/ эмийн урьдчилгаа төлбөрт 4,408,631.5 мянган төгрөгийг төлсөн нь нөлөөлжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 22,322,168.0 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 7,830,680.4 мянган төгрөгөөр буурчээ. Тайлант онд худалдан авсан бараа материал 46,669,613.3 мянган төгрөг, ЭМС-ын А/272 дугаар тушаалаар 332,873.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн

хэрэгсэл, А/05 дугаар тушаалаар 417,089.2 мянган төгрөг сэлбэг хэрэгсэл, А/360 дугаар тушаалаар 359,924.6 мянган төгрөгийн жижиг, багаж хэрэгсэл, харилцагч байгууллагуудаас 42,777.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авсан үнээр нэмэгдэж, эмнэлгийн үйл ажиллагаанд зарцуулсан 50,932,465.6 мянган төгрөг, эмнэлгийн ерөнхий захирлын 2025 оны А/424 дугаар тушаалаар хугацаа дууссан 763,050.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг, А/102 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй 833,658.3 мянган төгрөгийн багаж хэрэгслийг акталж устгасан дүнгээр хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 65,134,390.4 мянган төгрөг болж өмнөх оноос 12,862,843.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд худалдан авсан 612,291.7 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, программ хангамж, ЭМС-ын 2025 оны А/05 дугаар тушаалаар 1,008,963.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, А/234 дугаар тушаалаар 145,024.0 мянган төгрөгийн, А/356 дугаар тушаалаар 1,402,172.7 мянган төгрөгийн, А/357 дугаар тушаалаар 5,188,000.0 мянган төгрөгийн, А/360 тушаалаар 1,411,640.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус үнэ төлбөргүй авсан дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 305 тогтоолоор 2,366,977.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг, 558 тогтоолоор 458,894.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан дүнгээр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нь 13,152,634.3 мянган төгрөг болж өмнөх оноос 12,640,514.5 мянган төгрөгөөр буурсан нь ханган нийлүүлэгч байгууллагуудад өгөх эм, эмнэлгийн хэрэгслийн өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Эмнэлгийн үйл ажиллагаанд нийт 187,100.0 мянган төгрөгийн 5 программ хангамжийг ашигладаг бөгөөд тайлант онд систем хөгжүүлэлт, лицензийн төлбөрт 42,600.0 мянган төгрөгийг төлсөн байна. Тухайлбал: Эмнэл зүйн үйл ажиллагаанд ашигладаг e-health программын хөгжүүлэлтэд 36,000.0 мянган төгрөг, Дүрс оношилгооны зураг дамжуулах программын лицензийн төлбөрт 6,600.0 мянган төгрөгийг тус тус төлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас 103,475,057.4 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 1,052,062.4 мянган төгрөг тус тус санхүүжүүлэх, үйл ажиллагааны орлогоос 15,825,015.4 мянган төгрөг бүрдүүлж, нийт 120,352,135.2 мянган төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Эрүүл мэндийн сайдын А/07 дугаар тушаалаар бараа, үйлчилгээний зардлыг 4,190,741.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 1,050,726.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 116,220,330.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Үүнийг ТУЗ-ийн 1/02 дугаар тогтоолоор бараа, үйлчилгээний зардлыг 24,239,935.5 мянган төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийг 1,050,726.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 93,031,121.1 мянган төгрөгөөр баталжээ.

Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа бодит тоо мэдээг үндэслэн судалгаа, тооцоолол хийгээгүй, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

Тодотголоор батлагдсан төсвийг 15,698,153.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 2 удаа тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээнд зориулж 91,260,815.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, 17,468,459.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтэд 90,810,090.9 мянган төгрөгийг олгож, үйл ажиллагааны орлого 12,442,458.0 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 106,079,338.6 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,710,989.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 44,699.9 мянган төгрөг, дээд шатны төсвөөс хуваарилсан зардлыг 894,247.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| **1** | **71602** | **Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **108,729,275.0** | **106,079,338.6** | **2,649,936.4** | **97.6** |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 77,483,560.7 | 75,772,571.4 | 1,710,989.3 | 97.8 |
| 1.2 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 58,935.9 | 14,236.0 | 44,699.9 | 24.2 |
| 1.3 | 81639 | Төр төлбөрийг нь хариуцах санхүүжилт | 10,847,400.7 | 10,847,400.6 | - | 100.0 |
| 1.4 | 83601 | Олон улсын байгууллагаас олгосон санхүүжилт | 84,513.8 | 84,513.8 | - | 100.0 |
| 1.5 | 83603 | Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан | 20,254,863.9 | 19,360,616.7 | 894,247.2 | 95.6 |

Тус байгууллагын орон тоог ТУЗ-ийн тогтоолоор 750 байхаар баталж 22,849,499.3 мянган төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн боловч Эмнэлгийн захирлын А/23 дугаар тушаалаар үндсэн орон тоог 910, гэрээт ажилтан 28 орон тоотой баталж, нийт цалингийн зардлыг 8,569,369.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Гүйцэтгэлээр үндсэн орон тоог 114, гэрээт ажилтанг 18-аар тус тус бууруулж, нийт 1,284,513.1 мянган төгрөгийн цалингийн зардлыг дутуу зарцуулсан байна.

Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоотой 2023 онд байгуулсан 06 дугаартай хамтын гэрээгээр өдрийн унаа, хоолны зардлыг 10.0 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд тайлант хугацаанд 1,785,390.0 мянган төгрөгийг олгосон байна.

Удирдах ажилтнуудын зөвлөгөөн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй чиглэлийн сургалтын 2 арга хэмжээнд 19,400.0 мянган төгрөг, "Эмч, сувилагчаа сонсъё" сургалтын 3 арга хэмжээнд 61,351.7 мянган төгрөг, нийт 5 арга хэмжээнд зориулж 80,751.7 мянган төгрөгийн төсөв баталж, зарцуулсан байна.

ТУЗ-ийн буруу шийдвэрээр 2023 онд ажлаас халагдсан 1 албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс 53,893.0 мянган төгрөгийг олгосон бөгөөд буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын буцалтгүй тусламжаар 2 төсөл арга хэмжээнд зориулж 84,513.8 мянган төгрөг, Шинжлэх ухаан технологийн сангийн буцалтгүй тусламжаар 1 төсөл арга хэмжээнд зориулж 180,000.0 мянган төгрөг, нийт 261,513.8 мянган

төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гүйцэтгэлээр 2 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан, 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 78.0 хувьтай бөгөөд нийт 224,713.8 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц /хувь/ | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|
| Донороос цусны үүдэлэс шилжүүлэн суулгах менежмент | 2025.06.26-2025.08-30 | Донороос үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг нутагшуулах мөн хүүхдэд үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийх боломжийг бий болгох ба гадаад улсруу чиглэсэн мөнгөн урсгалыг бууруулах, ард иргэдэд анагаах ухааны дэвшилтэт технологийг хүртээмжтэй болгох | 100.0 | 52,613.6 | 52,613.6 |
| Сонсголын бэрхшээлийн эрүүл мэндийн төлөвлөлт | 2025.04.11-2025.06.30 | 1. Сургалтанд оролцогчидын сонсголын эрүүл мэндийн сорилт, шийдэл, стратегийн ахисан түвшний мэдлэг, мэдээлэл олгогдох 2. Төслийн удирдлага, бодлого боловсруулах чадвар эзэмших 3. Хамтын ажиллагааны харилцаа, холбоо тогтоогдох, ирээдүйд хамтран ажиллах боломжууд нээгдэх | 100.0 | 31,900.2 | 31,900.2 |
| Бөөрний эсийн өмөнгийн хэв шинжүүдийг радиологи-генетикийн шинжилгээгээр харьцуулан судлах нь | 2023.12.-2026.12 | 1. Бөөрний хавдар оношлогдсон өвчтөний КТГ-ийн шинжилгээнд 3D slicer программын тусламжтай радиомикс анализ хийх, 2. Бөөрний хавдар оношлогдсон 100 эмгэг судлалын шиншилгээнд BAR1, KDM5C зэрэг генийн мутациудыг тодорхойлох, 3 Бөөрний хавдар оношлогдсон өвчтөний КТГ-ийн шинжилгээнд хөндлөнгийн хяналт, баталгаажалт хийх 4. Эрдэм шинжилгээний өгүүлэл олон улсын сэтгүүл ( Web of Science ) болон Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх 5. Төслийн эцсийн тайлан, зөвлөмжийг бичиж захиалагч, санхүүжүүлэгчид хүлээлгэн өгөх | 78.0 | 180,000.0 | 140,200.0 |
| **Нийт дүн** | | | **-** | **261,513.8** | **224,713.8** |

Шинжлэх ухаан технологийн сангаас Бөөрний эсийн өмөнгийн хэв шинжүүдийг радиологи-генетикийн шинжилгээгээр харьцуулан судлах төсөл 2026 оны 12 дугаар сард хэрэгжиж дуусах бөгөөд хэрэгжилтийн явц 78.0 хувьтай байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус эмнэлгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 42,335,765.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 1,307,928.0 мянган төгрөгийн баталгаат засвар, 2,355,430.5 мянган төгрөгийн тусламж үйлчилгээний хоол, 798,041.5 мянган төгрөгийн эд хогшил худалдан авахаар, харьцуулалтын аргаар 2,001,651.0 мянган төгрөгийн багаж техник хэрэгсэл худалдан авахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 37,716,004.3 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 113,928.8 мянган төгрөг, нийт 37,829,933.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой хөрөнгийн ашиглалтыг нэмэгдүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитор Б.Отгонцэцэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/169 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 92,466,433.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 924,664.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ажилчин албан хаагчид дотоод нөөц бололцоогоо ашиглан жижиг засвар үйлчилгээг өөрсдөө хийж урсгал засварын зардлыг 10,814.98 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус эмнэлэг нь "Би энд и элит спийд спорт" ХХК-тай 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн УНТЭ/35/25 дугаартай гэрээ байгуулж сагс, волейбол, хөл бөмбөгийн өмсгөл, бэлтгэлийн хослолыг нийт 13,585.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

2. Тус эмнэлэг нь удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулахдаа өөрийн байрны 4 дүгээр давхарт байрлах хурлын заалыг ашиглахгүй, "Эн эс эн фанкшин" ХХК-тай Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж 9,500.0 мянган төгрөгийг шилжүүлж төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллагаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 96,286,404.0 мянган төгрөгийн 202 орлогын гүйлгээг, 69,506,149.5 мянган төгрөгийн 1338 зарлагын гүйлгээг хуулийн хугацаанд тус тус мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 4,078.6 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 32,785,812.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг жилийн эцсийн аудитаар дахин хянаж үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг таслан зогсоох 716,650.6 мянган төгрөгийн 6 албан шаардлага, 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 6 | 716,650.6 | 6 | 716,650.6 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | - | 3 | - | 100.0 |
| **Нийт дүн** | **9** | **716,650.6** | **9** | **716,650.6** | **100.0** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журамд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг нь эдийн засгийн ангилалтай нийцүүлээгүй, хураангуйлсан байгаа нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдол бага байгаа тул журмыг дахин боловсруулах шаардлагатай байна.
2. Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад сар бүр 10.0-25.0 хувиар ур чадварын нэмэгдлийг бодож, нийт 1,102,072.3 мянган төгрөгийг олгосон бөгөөд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг батлаагүй байгаа нь салбарын хувьд жигд бус байна.
3. Бараа материалын бүртгэлийг сайжруулахтай холбоотойгоор хийгдэж байгаа эм савлалтын нэгдсэн системийн хөгжүүлэлтийг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,052,086.2 мянган төгрөгийн 3 алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,052,086.2 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Амбулаторийн эмийн сангаар худалдсан эмийн тоо ширхгийн хэмжээнд мөнгөн дүнг бичиж буруу шивснээс шалтгаалан E-health программын орлогын бүртгэлийг, санхүүгийн программын орлогын бүртгэлээс 1,012,500.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн;
- Хандивын орлогоос худалдан авсан 357.6 мянган төгрөгийн хяналтын камер, 840.0 мянган төгрөгийн түлхүүрийн оосрыг санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй;
- Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд "Үлэмж эс жи жи" компаниас авах авлагаа барагдуулсныг 38,388.6 мянган төгрөгийн хөрөнгө өгснийг үнэ төлбөргүй авсан хөрөнгөөр буруу тайлагнасан.

Энэ нь УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 8,135,576.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 53,337.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 7,793,072.6 мянган төгрөгийн 16 албан шаардлага хүргүүлж, 289,166.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 8,135,576.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 7,210,911.7 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тус эмнэлгийн А блокийн 2 дугаар давхарт байрлах 288 мкв талбай бүхий цайны газрыг "Үлэмж эс жи жи катеринг" ХХК-тай түрээсийн гэрээ байгуулаагүй шалтгаанаар төлбөргүй ашиглуулж, тайлант онд 51,840.0 мянган төгрөгийн түрээсийн орлого аваагүй байна.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дэх хэсэгт "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" 49 дүгээр тогтоолын хавсралтын 1 дүгээрт "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Түрээсийн гэрээ байгуулаагүй, төлбөргүй ашиглуулсан талбайн төлбөрийг Үлэмж эс жи жи катеринг ХХК-аар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн 1 ажилтанд 1-2 дугаар сард нийт 1,497.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

**5.2 Албан шаардлага**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулсан 3 байгууллагын 129,894.7 мянган төгрөгийн гэрээг дүгнээгүй, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ханган нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг дүгнээгүй, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

2. Тус эмнэлгийн 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж эм, эмнэлгийн хэрэгслийн тендерт шалгарсан 6 аж ахуйн нэгжээс 54,500.0 мянган төгрөгийн мөнгөн хандив, 2 түрээслэгчээс 229,088.8 мянган төгрөгийн их засварын ажил, нийт 283,588.8 мянган төгрөгийн хандивыг хамаарал бүхий этгээдээс авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно", 25.5.1-д "хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хамаарал бүхий этгээдээс хандив, тусламж авдаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

3. Эрүүл мэндийн сайдын А/350 дугаар тушаалын дагуу тус эмнэлэг нь 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахдаа ажилтны хувийн харилцах дансаар, бэлэн болон бэлэн бус хэлбэрээр нийт 723,950.5 мянган төгрөгийн хандивын орлого бүрдүүлж, 6 арга хэмжээнд зарцуулснаас 226,321.8 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөн зохион байгуулсан ажилтны хувийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 39,453.6 мянган төгрөгийг он дамжуулан 2026 оны 1 дүгээр сард зарцуулсан байна.Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандив, тусламжийн орлогыг хувийн харилцах дансанд хүлээн авсан, бүрэн тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтгүй, зарцуулсан зэрэг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

4. Тус эмнэлэг нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон 12 түрээслэгчтэй байгуулсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ"-д заасны дагуу түрээсийн 1 сарын барьцаа төлбөр болох нийт 45,041.5 мянган төгрөгийг урьдчилан байршуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний 3.3-т "Түрээслэгч нь гэрээний үүргээ биелэлтийн баталгаа болгож 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээний төлбөрийг барьцаа болгон түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулан энэхүү гэрээний хугацаанд байлгана" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

5. Тус эмнэлгийн 1 дүгээр давхарт байрлах диализийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай 720 мкв талбайг "Их шүүдэргэнэ импорт" ХХК-д 2021 оноос хойш 1 мкв-ыг 15.0 мянган төгрөг буюу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоосон жишиг доод үнээр тооцон түрээслүүлж байгаа бөгөөд эмнэлгийн дундаж түрээсийн үнээр шинэчлэн тогтоогоогүй, мөн байгууллагын дансанд бүртгэлтэй диализын эмчилгээнд ашигладаг 11 ширхэг аппарат, 5 ширхэг усны төхөөрөмжүүдийг үнэ төлбөргүй ашиглуулж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.3-д "үр ашигтай байх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн төлбөрийг эмнэлгийн дундаж түрээсийн үнэтэй нийцүүлэн шинэчлэн тогтоогоогүй, диализын тоног төхөөрөмжүүдийг төлбөргүй ашиглуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

6. Тус эмнэлэг нь нийт 11 тасгийн төлбөртэй өрөөний орлогын тооцоо бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөртэй өрөөний орлогын тооцоо бодоогүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

7. Тайлант хугацаанд тус байгууллагын ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан тухайн сарын ажлын цагийн 10.0 хувиас хэтрүүлэн 31 хүнд 2,218 цагийн нийт 46,571.3 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т заасснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо холбогдох журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

8. Тус эмнэлэг нь Тагнуулын ерөнхий газрын албан бичиггүй архивын эрхлэгч, мэдээлэл технологийн албаны инженер, ерөнхий захирлын туслах гэсэн 3 албан тушаалтанд эмнэлгийн даргын тушаалаар нууцын нэмэгдлийг сар бүр 20-30 хувиар тооцож, нийт 7,111.5 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2-т "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно", 4.1-т "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох эрх бүхий байгууллагын албан бичиггүй нууцын нэмэгдэл олгодог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

9. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын импортын эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад үнийн санал, төлбөрийн нөхцөлийг нь батлуулалгүй Такролимус капсул /дархлаа дарангуйллын/ эмийг тус эмнэлэг нь Нидерланд улсын "Астелас Фарма" компаниас 5,827,273.7 мянган төгрөгөөр шууд худалдан авсан байна. Энэ нь Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д "Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран энэ хуулийн 47.1-д заасан бүтээгдэхүүний нэр төрлийг гаргаж, улсын хэмжээний хэрэгцээг нэгтгэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ", 47.3-д "Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн энэ хуулийн 47.2-т заасан хэрэгцээг үндэслэн энэ хуулийн 47.1-д заасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг 3 хүртэлх жилээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор баталсан "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ын 1.2-т "Олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас худалдан авах ажиллагааг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, үйлдвэрлэгчээс худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.1, 45.2, 45.4, 45.7-д заасны дагуу тус тус зохион байгуулна", 3.1.3-т "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн үнийн санал, төлбөрийн нөхцөлийг үндэслэн олон улсын байгууллагад худалдан авах захиалга хүргүүлэх", 3.2.1-д "олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах боломжгүй эм, эмнэлгийн хэрэгслийг гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус эмнэлэг нь удаан хугацааны нөхөн эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх үйлчилгээний эмийн бүтээгдэхүүнийг шууд худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

10. Тус эмнэлэг нь тайланд онд "Онцлог тусламж үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах" тендерийн 53 дугаар багцын эмийн босго үнийг 529,747.4 мянган төгрөгөөр цахим системд байршуулсан байхад "Жэй эм би" ХХК-д 570,809.4 мянган төгрөгийн гэрээ байгуулах эрх олгож, төсөвт өртгөөс 41,062.0 мянган төгрөгөөр илүү гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10-д "Энэ хуулийн 26.9-д зааснаас бусад тендер болон дараах тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана", 26.10.1-д "тендерийн үнэ

төсөвт өртгөөс, эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа төсөвт өртгөөс илүү үнээр гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

11. Тус эмнэлэг нь тайланд онд хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас 224,696.5 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал бэлтгэж төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 2 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангилал зөрчиж зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

12. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2020 онд баригдсан 655,110.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 638,791.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 16 суудлын машины багтаамжтай "Кар сити" давхар зогсоолыг Нийслэлийн авто зам хөгжлийн газрын 2022 оны 6/702 дугаар албан бичиг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны А/1/1890 дугаар албан бичгийг тус тус үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд орлогод авсан боловч зогсоолыг одоог хүртэл ашиглаагүй, тус эмнэлгийн хашаанд хэсэгчлэн салгаж хураасан, хэрэгцээ шаардлагагүй, ашиглалтгүй хөрөнгө бий болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.2.2-т "Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн тус байгууллагад хэрэгцээгүй, ашиглалтгүй байгаа хөрөнгийн асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад хандан хэрэгцээтэй газарт нь шилжүүлэх арга хэмжээг авч шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүллээ.

13. Эмнэлгийн "Тусгай үйлчилгээтэй тасаг VIP" төлбөртэй өрөөний орлогоос 1-10 дугаар сард нийт 15 хүний ор хоногийн төлбөр 8,732.0 мянган төгрөгийг ерөнхий захирлын зөвшөөрлөөр, үндэслэх баримтгүйгээр чөлөөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Эрүүл мэндийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 1.2.5-д "Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана", Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/263 дугаар тушаалаар баталсан "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нөхцөл сайжруулсан орны үйлчилгээний журам"-

ын 6.2-т "Үндэслэлгүйгээр төлбөрийг чөлөөлөх, буцаан олгохыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эмнэлгийн нөхцөл сайжруулсан орны үйлчилгээний журмыг мөрдөөгүй, төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг хүндэтгэн үзэх шалтгаангүй захирлын зөвшөөрлөөр чөлөөлдөг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

14. Тус эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд нь иргэний нэхэмжлэлтэй холбоотой шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөллийн үйлчилгээ авахаар 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр өмгөөлөгчтэй гэрээ байгуулж 10,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг шилжүүлж, гүйцэтгэсэн ажлын тайлангүй, зардалд бүртгэж, үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

*1.1 Илрүүлэлт*

Ковидын үед Эрүүл мэндийн яамнаас хандиваар үнэ төлбөргүй хуваарилсан 5848 ширхэг 103,341.5 мянган төгрөгийн нэг удаагийн комбинезон, 6321 ширхэг 47,252.5 мянган төгрөгийн нүдний шил, 11253 ширхэг 18,711.4 мянган төгрөгийн нүүрний хаалт, 1730 ширхэг 13,998.4 мянган төгрөгийн N95 маск, 3006 ширхэг 4,762.3 мянган төгрөгийн KN95 маск, 18000 ширхэг 99,000.0 мянган төгрөгийн ковид-19 тест, УНТЭ-ийн үндсэн гэрээгээр худалдан авсан 435 ширхэг 2,099.7 мянган төгрөгийн гипстэй боолт зэрэг нийт 289,166.3 мянган төгрөгийн хугацаа дуусан бараа материалын үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Бараа материалын ашиглалтыг сайжруулж, хэрэгцээ шаардлагагүй бараа материалын нөөц үүсгэсэн зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмж биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Амбулаторийн эмийн сангаар худалдсан эмийн тоо ширхгийн дүн дээр мөнгөн дүнг бичиж буруу шивснээс шалтгаалан E-health программын орлогын бүртгэл, санхүүгийн программын орлогын бүртгэлээс 1,012,500.0 мянган төгрөгөөр илүү байна. | 1 | 1,012,500.0 | | | 1 | 1,012,500.0 | 1 | 1,012,500.0 | | | | |
| 2 | Хандивын орлогоос худалдан авсан 357.6 мянган төгрөгийн хяналтын камер, 840.0 мянган төгрөгийн түлхүүрийн оосрыг санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй. | 1 | 1,197.6 | 1 | 1,197.6 | | | 1 | 1,197.6 | | | | |
| 3 | Үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд "Үлэмж эс жи жи" компаниас авах авлагаа барагдуулж 38,388.6 мянган төгрөгийн хөрөнгө өгснийг үнэ төлбөргүй авсан хөрөнгөөр тайлагнасан. | 1 | 38,388.6 | | | 1 | 38,388.6 | 1 | 38,388.6 | | | | |
| | **Дүн** | **3** | **1,052,086.2** | **1** | **1,197.6** | **2** | **1,050,888.6** | **3** | **1,052,086.2** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Жилийн эцэст 3 байгууллагын 129,897.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээг дүгнээгүй, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй | 1 | 129,894.7 | | | 1 | 129,894.7 | | | | | | |
| 2 | Эмнэлгийн 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж эм, эмнэлгийн хэрэгслийн тендерт шалгарсан 6 аж ахуйн нэгжээс 54,500.0 мянган төгрөгийн мөнгөн хандив, 2 түрээслэгчээс 229,088.8 мянган төгрөгийн их засварын ажил, нийт 283,588,8 мянган төгрөгийн хандивыг хамаарал бүхий этгээдээс авсан. | 1 | 283,588.8 | | | 1 | 283,588.8 | | | | | | |
| 3 | Эрүүл мэндийн сайдын А/350 дугаар тушаалын дагуу тус эмнэлэг нь 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахдаа 1 ажилтны хувийн дансаар 289,763.7 мянган төгрөг, бэлэн мөнгөөр 10,283.4 мянган төгрөг, бусад байдлаар 423,903.4 мянган төгрөг нийт 723,950.5 мянган төгрөгийн хандивын орлого бүрдүүлж 6 арга хэмжээнд зарцуулснаас 226,321.8 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөн зохион байгуулсан ажилтны хувийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 39,453.6 мянган төгрөгийг он дамжуулан 2026 оны 1 дүгээр сард зарцуулсан. | 1 | 265,785.4 | | | 1 | 265,785.4 | | | | | | |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙ ХЯНАЛТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Тус эмнэлэг нь ТӨБЗГ болон 12 түрээслэгчтэй байгуулсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ"-д заасны дагуу түрээсийн 1 сарын барьцаа төлбөр, нийт 45,041.5 мянган төгрөгийг урьдчилан байршуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй. | 1 | 45,041.5 | | | 1 | 45,041.5 | | | | | | |
| 5 | Тус эмнэлгийн А блокын 2 дугаар давхарт байрлах 288 мкв талбай бүхий цайны газрыг "Үлэмж эм жи жи катеринг" ХХК-д ашиглуулдаг бөгөөд түрээсийн гэрээ байгуулаагүйгээс 1-12 сард үнэ төлбөргүй ашиглуулж, нийт 51,840.0 мянган төгрөгийн түрээсийн орлого аваагүй. | 1 | 51,840.0 | 1 | 51,840.0 | | | | | | | | |
| 6 | Тус эмнэлгийн 1 дүгээр давхарт байрлах диализийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай 720 мкв талбайг "Их шүүдэргэнэ импорт" ХХК-д 2021 оноос хойш 1 мкв-ийг 15,000 төгрөг буюу ТӨБЗГ-аас тогтоосон жишиг доод үнээр тооцож түрээслүүлж байгаа байгаа эмнэлгийн дундаж түрээсийн үнээр шинэчлэн тогтоогоогүй, мөн байгууллагын дансанд бүртгэлтэй диализын эмчилгээнд ашигладаг 11 ширхэг аппарат, 5 ширхэг усны төхөөрөмжүүдэд түрээсийн төлбөр авдаггүй ашиглуулж байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| 7 | Нийт 11 тасгийн төлбөртэй өрөөний орлогын тооцоо бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй | 1 | 241,439.0 | | | 1 | 241,439.0 | | | | | | |
| 8 | Тайлант хугацаанд тус байгууллагын ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 31 хүнд 2,218 цагийн нийт 46,571.3 мянган төгрөгийг олгосон байна. | 1 | 46,571.3 | | | 1 | 46,571.3 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Тус байгууллагын мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн 1 ажилтанд 1-2 сард нийт 1,497.0мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон. | 1 | 1,497.0 | 1 | 1,497.0 | | | | | | | | |
| 10 | ТЕГ-ын албан бичиггүй архивын эрхлэгч, мэдээлэл технологийн албаны инженер, ерөнхий захирлын туслах гэсэн 3 албан тушаалтанд тус эмнэлгийн даргын тушаалаар нууцын нэмэгдлийг сар бүр 20-30 хувиар тооцож, нийт 7,111.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг олгосон | 1 | 7,111.4 | | | 1 | 7,111.4 | | | | | | |
| 11 | Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Шууд гэрээ байгуулан худалдан авах эм дархлаажуулах бэлдмэл, цус цусан бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгслийн жагсаалт" 71 дүгээр тогтоолоор, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуулийн холбогдох заалтыг үндэслэн баталсан байна. Гэвч эдгээр хуулийн заалтад нэмэлт, өөрчлөлт орж, тогтоолын үндэслэл болсон заалтууд хүчингүй болсон бөгөөд хүчин төгөлдөр бус тогтоолыг үндэслэн Нидерланд улсын "Астелас Фарма" компаниас Такролимус капсул /дархлаа дарангуйллын/ эмийг 5,827,273.8 мянган төгрөгөөр шууд худалдан авсан | 1 | 5,827,273.8 | | | 1 | 5,827,273.8 | | | | | | |
| 12 | Тайланд онд "Онцлог тусламж үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах" тендерийн 53 дугаар багцын эмийн босго үнийг 529,747.4 мянган төгрөгөөр tender.gov.mn цахим системд байршуулсан байхад "Жэй эм би" ХХК-д 570,809.4 мянган төгрөгийн гэрээ байгуулах эрх олгож, төсөвт өртгөөс 41,062.0 мянган төгрөгөөр илүү гэрээ байгуулсан | 1 | 41,062.0 | | | 1 | 41,062.0 | | | | | | |



01 ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯНАЛТ ШАЛГАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас 224,696.4 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал авч зардлын ангилал зөрчиж зарцуулсан. | 1 | 224,696.5 | | | 1 | 224,696.5 | | | | | | |
| 14 | Ковидын үед Эрүүл мэндийн яамнаас хандиваар үнэ төлбөргүй хуваарилсан 5848 ширхэг 103,341.5 мянган төгрөгийн нэг удаагийн комбинзон, 6321 ширхэг 47,252.5 мянган төгрөгийн нүдний шил, 11253 ширхэг 18,711.4 мянган төгрөгийн нүүрний хаалт, 1730 ширхэг 13,998.4 мянган төгрөгийн N95 маск, 3006 ширхэг 4,762.3 мянган төгрөгийн KN95 маск, 18000 ширхэг 99,000.0 мянган төгрөгийн ковид-19 тест, УНТЭ-ийн үндсэн гэрээгээр худалдан авсан 435 ширхэг 2,099.7 мянган төгрөгийн гипстэй боолт, зэрэг нийт 289,166.3 мянган төгрөгийн хугацаа дуусан бараа материалын үлдэгдэлтэй байна. | 1 | 289,166.3 | | | | | 1 | 289,166.3 | | | | |
| 15 | Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2020 онд баригдсан 655,110.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 638,791.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 16 суудлын машины багтаамжтай "Кар сити" давхар зогсоолыг Нийслэлийн авто зам хөгжлийн газрын 2022 оны 6/702 дугаар албан бичиг, ТӨБЗГ-ын 2022 оны А/1/1890 дугаар албан бичгийг тус тус үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд орлогод авсан боловч зогсоолыг одоог хүртэл ашиглаагүй, тус эмнэлгийн хашаанд хэсэгчлэн салгаж хураасан, хэрэгцээ шаардлага хангахгүй, ашиглалтгүй хөрөнгө бий болсон | 1 | 638,791.3 | | | 1 | 638,791.3 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Иргэний нэхэмжлэлтэй Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөллийн үйлчилгээ авахаар 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр өмгөөлөгч Г.Болорцэцэгтэй гэрээ байгуулж 10,000.0 мянган төгрөгийн урьдчилгааг шилжүүлж ажлын тайлангүй, зардалд бүртгэж, үр ашиггүй зардал гаргасан | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | | | | | | |
| 17 | Эмнэлгийн "Тусгай үйлчилгээтэй тасаг VIP" төлбөртэй өрөөний орлогоос 1-10 дугаар сард нийт 15 хүний ор хоногийн төлбөр 8,732.0 мянган төгрөгийг ерөнхий захирлын зөвшөөрлөөр үндэслэлгүй чөлөөлсөн | 1 | 8,732.0 | | | 1 | 8,732.0 | | | | | | |
| 18 | "Би энд и элит спийд спорт" ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн УНТЭ/35/25 дугаартай гэрээ байгуулж сагсны өмсгөл, волейболын өмсгөл, хөл бөмбөгийн өмсгөл, футболк, шорт, өмд, цахилгаантай цамц, бэлтгэлийн хослолд нийт 13,585.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үрэлгэн зарцуулсан. | 1 | 13,585.0 | | | 1 | 13,585.0 | | | | | | |
| 19 | Тус эмнэлэг нь удирдах ажилтны зөвлөгөөний хурлыг зохион байгуулахдаа өөрийн байрны 4 дүгээр давхарт байрлах хурлын заалыг ашиглахгүй, "Эн эс эн фанкшин" ХХК-тай Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж 9,500.0 мянган төгрөгийг шилжүүлж төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан | 1 | 9,500.0 | | | 1 | 9,500.0 | | | | | | |
| | **Дүн** | **19** | **8,135,576.0** | **2** | **53,337.0** | **16** | **7,793,072.7** | **1** | **289,166.3** | **-** | **-** | **-** | **-** |



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЫН ТҮЛЙ САНГ... ХХК

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 28/А ОТА1275 САГ-2026/233/НА-СТА-ТШЗ Улаанбаатар хот

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлгийн А блокийн 2 дугаар давхарт байрлах 288 мкв талбай бүхий цайны газарт "Үлэмж эс жи жи катеринг" ХХК-тай түрээсийн гэрээ байгуулаагүй, үнэ төлбөргүй ашиглуулж тайлант онд 51,840,000.00 */тавин нэгэн сая найман зуун дөчин мянга/* төгрөгийн түрээсийн орлого аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дэх хэсэгт "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр батлсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" 49 дүгээр тогтоолын хавсралтын 1 дүгээрт "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.2-д *"төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй"* гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Түрээсийн гэрээ байгуулаагүй, үнэ төлбөргүй ашиглуулсан талбайн түрээсийн төлбөр 51,840,000.00 */тавин нэгэн сая найман зуун дөчин мянга/* төгрөгийг "Үлэмж эс жи жи катеринг" ХХК-аар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 29/А0171275 Улаанбаатар хот

САГ-2026/233/НА-СТА-ТШ3

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн 1 ажилтанд 1-2 дугаар сард нийт 1,496,961.00 */нэг сая дөрвөн зуун ерэн зургаан мянга есөн зуун жаран нэг/* төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Илүү тооцож олгосон 1,496,961.00 */нэг сая дөрвөн зуун ерэн зургаан мянга есөн зуун жаран нэг/* төгрөгийг нягтлан бодогч Ч.Мөнхзаяагаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Akt\20260225 SAG-16.Docx

1526200075

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25. өдөр Дугаар 191/А01/71275 Улаанбаатар хот

САТ-2026/233/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээ байгуулсан 3 байгууллагын 129,894,687.00 */нэг зуун хорин есөн сая найман зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун наян долоо/* төгрөгийн гэрээг дүгнээгүй, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын *4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"* гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг дүгнээгүй, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx*

1526180438

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 192/А017275 САГ-2026/233/НА-СТА-ТШЗ Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлгийн 100 жилийн ойн арга хэмжээнд зориулж эм, эмнэлгийн хэрэгслийн тендерт шалгарсан 6 аж ахуйн нэгжээс 54,500,000.00 */тавин дөрвөн сая таван зуун мянга/* төгрөгийн мөнгөн хандив, 2 түрээслэгчээс 229,088,837.00 */хоёр зуун хорин есөн сая наян найман мянга найман зуун гучин долоо/* төгрөгийн их засварын ажил, нийт 283,588,837.00 */хоёр зуун наян гурван сая таван зуун наян найман мянга найман зуун гучин долоо/* төгрөгийн хандивыг хамаарал бүхий этгээдээс авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Дараах тохиолдлыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэн төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглоно", 25.5.1-д "хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-т "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хамаарал бүхий этгээдээс хандив, тусламж авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180440

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 193/АД71275 Улаанбаатар хот
САГ-2026/233/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон 12 түрээслэгчтэй байгуулсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ"-д заасны дагуу түрээсийн 1 сарын барьцаа төлбөр болох нийт 45,041,500.00 */дөчин таван сая дөчин нэгэн мянга таван зуу/* төгрөгийг урьдчилан байршуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх", Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний 3.3-т "Түрээслэгч нь гэрээний үүргээ биелэлтийн баталгаа болгож 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээний төлбөрийг барьцаа болгон түрээслүүлэгчийн түрээсийн төлбөр авах дансанд урьдчилан байршуулан энэхүү гэрээний хугацаанд байлгана" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.8-д "*байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргээ биелүүлээгүй, 1 сарын барьцаа төлбөрийг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180444

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 194/0171275 Улаанбаатар хот
САГ- 2026/233/НА-СТА-ПШ3

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлгийн 1 дүгээр давхарт байрлах диализийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай 720 мкв талбайг "Их шүүдэргэнэ импорт" ХХК-д 2021 оноос хойш 1 мкв-ийг 15,000.00 */арван таван мянга/* төгрөг буюу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоосон жишиг доод үнээр тооцож түрээслүүлж байгаа бөгөөд эмнэлгийн дундаж түрээсийн үнээр шинэчлэн тогтоогоогүй, мөн байгууллагын дансанд бүртгэлтэй диализийн эмчилгээнд ашигладаг 11 ширхэг аппарат, 5 ширхэг усны төхөөрөмжүүдийг түрээсгүй, үнэ төлбөргүй ашиглуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.3-д "үр ашигтай байх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түрээсийн төлбөрийг эмнэлгийн дундаж түрээсийн үнэтэй нийцүүлэн шинэчлэн тогтоогоогүй, диализийн тоног төхөөрөмжүүдээс түрээсийн төлбөр аваагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | | |
|---|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\20260125 SAG-23.Docx

1526180446

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 195/А017275 Улаанбаатар хот

САГ-2026/233/НА- ОТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь нийт 11 тасгийн төлбөртэй өрөөний орлогын тооцоо бодоогүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.1-т *"нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"* гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлбөртэй өрөөний орлогын тооцоо бодоогүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180448

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 196/АД17/275
САТ-2026/233/НА-СТА-ТШЗ Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд тус байгууллагын ажилчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 31 хүнд 2,218 цагийн нийт 46,571,300.00 */дөчин зургаан сая таван зуун далан нэгэн мянга гурван зуу/* төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т заасныг бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгохдоо холбогдох журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180450

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 197/А0171275 Улаанбаатар хот
САГ-2026/233/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь Тагнуулын ерөнхий газрын албан бичиггүй архивын эрхлэгч, мэдээлэл технологийн албаны инженер, ерөнхий захирлын туслах гэсэн 3 албан тушаалтанд эмнэлгийн даргын тушаалаар нууцын нэмэгдлийг сар бүр 20-30 хувиар тооцож, нийт 7,111,387.00 */долоон сая нэг зуун арван нэгэн мянга гурван зуун наян долоо/* төгрөгийн нэмэгдэл цалинг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2-т "Нууц хамгаалах ажилтнаар тагнуулын байгууллагын Аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж тэнцсэн хүнийг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно", 4.1-т "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.11-д "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох эрх бүхий байгууллагын албан бичиггүй нууцын нэмэгдэл олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180452

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 198/АОГ/1275 САГ-2026/233/НА-СТА ТШЗ Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын А/350 дугаар тушаалын дагуу тус эмнэлэг нь 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулахдаа ажилтны хувийн харилцах дансаар, бэлэн болон бэлэн бус хэлбэрээр нийт 723,950,500.00 */долоон зуун хорин гурван сая есөн зуун тавин мянга таван зуу/* төгрөгийн хандивын орлого бүрдүүлж 6 арга хэмжээнд зарцуулснаас 226,321,800.00 */хоёр зуун хорин зургаан сая гурван зуун хорин нэгэн мянга найман зуу/* төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, мөн зохион байгуулсан ажилтны хувийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 39,453,600.00 */гучин есөн сая дөрвөн зуун тавин гурван мянга зургаан зуу/* төгрөгийг он дамжуулан 2026 оны 1 дүгээр сард зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.1-д "*нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180442

1. Хандив, тусламжийн орлогыг хувийн харилцах дансанд хүлээн авсан, бүрэн тайлагнаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, баримтгүй, зарцуулсан зэрэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 199/А01/1275 Улаанбаатар хот
САГ-2026/233/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь удаан хугацааны нөхөн эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх үйлчилгээний эм бүтээгдэхүүний улсын хэмжээний хэрэгцээг судалж, нэр төрлийг 3 хүртэлх жилээр нэгтгэн гаргаж, батлах бөгөөд эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн үнийн санал, төлбөрийн нөхцөлийг үндэслэн олон улсын байгууллагад захиалга өгч, гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах ёстой Такролимус капсул /дархлаа дарангуйллын/ эмийг тус эмнэлэг нь Нидерланд улсын "Астелас Фарма" компаниас 5,827,273,750.00 */таван тэрбум найман зуун хорин долоон сая хоёр зуун далан гурван мянга долоон зуун тавь/* төгрөгөөр шууд худалдан авсан байна.

Энэ нь Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-д "Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран энэ хуулийн 47.1-д заасан бүтээгдэхүүний нэр төрлийг гаргаж, улсын хэмжээний хэрэгцээг нэгтгэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ", 47.3-д "Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн энэ хуулийн 47.2-т заасан хэрэгцээг үндэслэн энэ хуулийн 47.1-д заасан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг 3 хүртэлх жилээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ын 1.2-т "Олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас худалдан авах ажиллагааг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, үйлдвэрлэгчээс худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.1, 45.2, 45.4, 45.7-д заасны дагуу тус тус зохион байгуулна", 3.1.3-т "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн үнийн санал, төлбөрийн нөхцөлийг үндэслэн олон улсын байгууллагад худалдан авах захиалга хүргүүлэх", 3.2.1-д "олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах боломжгүй эм, эмнэлгийн хэрэгслийг гадаад улсын үйлдвэрлэгчээс худалдан авах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180454

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.8-д "*байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус эмнэлэг удаан хугацааны нөхөн эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх үйлчилгээний эмийн бүтээгдэхүүнийг шууд худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, Олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас худалдан авах ажиллагааг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 200/А0171275 Улаанбаатар хот
САГ-2026/Q33/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь тайланд онд "Онцлог тусламж үйлчилгээний эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах" тендерийн 53 дугаар багцын эмийн босго үнийг 529,747,400.00 */таван зуун хорин есөн сая долоон зуун дөчин долоон мянга дөрвөн зуу/* төгрөгөөр цахим системд байршуулсан байхад "Жэй эм би" ХХК-д 570,809,400.00 */таван зуун далан сая найман зуун есөн мянга дөрвөн зуу/* төгрөгийн гэрээ байгуулах эрх олгож, төсөвт өртгөөс 41,062,000.*00 /дөчин нэгэн сая жаран хоёр мянга/* төгрөгөөр илүү гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10-д "Энэ хуулийн 26.9-д зааснаас бусад тендер болон дараах тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана", 26.10.1-д "тендерийн үнэ төсөвт өртгөөс, эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.9-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа төсөвт өртгөөс илүү үнээр гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180456

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 201/А0171275 Улаанбаатар хот
САГ-2026/02/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь тайланд онд хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас 224,696,450.00 */хоёр зуун хорин дөрвөн сая зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун тавь/* төгрөгийн цэвэрлэгээний материал бэлтгэж төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" 2 дугаар хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-тай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.6-д "*төсвийг зориулалт бусаар зарцуулсан*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг ангилал зөрчиж зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx*

1526180458

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 202/А017/275 САГ-2026/233/НА-СТА-1013 Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2020 онд баригдсан 655,110,800.00 */зургаан зуун тавин таван сая нэг зуун арван мянга найман зуу/* төгрөгийн төсөвт өртөгтэй, 638,791,300.00 */зургаан зуун гучин найман сая долоон зуун ерэн нэгэн мянга гурван зуу/* төгрөгийн үлдэх өртөгтэй 16 суудлын машины багтаамжтай "Кар сити" давхар зогсоолыг Нийслэлийн авто зам хөгжлийн газрын 2022 оны 6/702 дугаар албан бичиг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны А/1/1890 дугаар албан бичгийг тус тус үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд орлогод авсан боловч зогсоолыг одоог хүртэл ашиглаагүй, тус эмнэлгийн хашаанд хэсэгчлэн салгаж хураасан, хэрэгцээ шаардлага хангахгүй, ашиглалтгүй хөрөнгө бий болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.2.2-т "Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.4-т "*төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэрэгцээ шаардлага хангахгүй, ашиглалтгүй хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180460

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 203/А017/1275 Улаанбаатар хот
САГ-2026/233/НА-СТА-1213

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь "Би энд и элит спийд спорт" ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн УНТЭ/35/25 дугаартай гэрээ байгуулж сагс, волейбол, хөл бөмбөгийн өмсгөл, бэлтгэлийн хослолыг нийт 13,585,000.00 */арван гурван сая таван зуун наян таван мянга/* төгрөгөөр худалдан авч төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "*төсвийг зориулалт бусаар зарцуулсан*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180462

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 204/А017/275 Улаанбаатар хот

САГ-2026/023/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлэг нь удирдах ажилтны зөвлөгөөний хурлыг зохион байгуулахдаа өөрийн байрны 4 дүгээр давхарт байрлах хурлын заалыг ашиглахгүй, "Эн эс эн фанкшин" ХХК - тай Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж 9,500,000.00 */есөн сая таван зуун мянга/* төгрөгийг шилжүүлж төсвийг хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх " гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.6-д *"төсвийг зориулалт бусаар зарцуулсан"* гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Albon Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

152618046

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 205/АО/71275 Улаанбаатар хот
САТ-2026/233/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд иргэний нэхэмжлэлтэй холбоотой, шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөллийн үйлчилгээ авахаар 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр өмгөөлөгчтэй гэрээ байгуулж 10,000,000.00 */арван сая/* төгрөгийн урьдчилгааг шилжүүлж, ажлын тайлангүй, зардалд бүртгэж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл суурьиар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам-ын 4.2.1.4-д "*төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчлийг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180466

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 206/А017/275 Улаанбаатар хот
САГ-2026/233/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмнэлгийн "Тусгай үйлчилгээтэй тасаг VIP" төлбөртэй өрөөний орлогоос 1-10 дугаар сард нийт 15 хүний ор хоногийн төлбөр 8,732,000.00 */найман сая долоон гучин хоёр мянга/* төгрөгийг ерөнхий захирлын зөвшөөрлөөр үндэслэлгүй чөлөөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Эрүүл мэндийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 1.2.5-д "Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээнээс олсон орлогыг эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэлийн болон санхүүгийн программд бүртгэж, тайлагнаж ажиллана", Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/263 дугаар тушаалаар баталсан "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нөхцөл сайжруулсан орны үйлчилгээний журам"-ын 6.2-т "Үндэслэлгүйгээр төлбөрийг чөлөөлөх, буцаан олгохыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.8-д "*байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эмнэлгийн нөхцөл сайжруулсан орны үйлчилгээний журмыг мөрдөөгүй, төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг хүндэтгэн үзэх шалтгаангүй захирлын зөвшөөрлөөр чөлөөлдөг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Анхтуяа/, Санхүү албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-23.Docx

1526180468

# ТЭМДЭГЛЭЛ

## ТЭМДЭГЛЭЛ

## ТЭМДЭГЛЭЛ

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг